

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

С. Дашцэвэл

**ЭНЭТХЭГ-ХЯТАДЫН ХОЙГИЙН АРД ТҮМНИЙ ЯЛАЛТ,
БЭЭЖИНГИЙН БОДЛОГО**

Империалист түрэмгийллийн эсрэг баатарлаг Вьетнамын ард түмэн олон жилийн турш явуулсан шударга тэмцлийн үрээр 1975 онд Энэтхэг Хятадын хойгт дайны галыг унтрааж колонилол, шинэ колонилолын эсрэг тэмцэлд шийдвэрлэх хувь нэмэр оруулсан билээ. Энэхүү ялалт нь «Өөрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эрх чөлөөг бүхий л аргаар эрс шийдвэртэй хамгаалж олон улсын өргөн дэмжлэг авч байгаа улс түмэн одоо үед империалист түрэмгийллийг няцаах улам их бололцоотой болж байна»¹ гэсэн коммунист, ажилчны намуудын 1969 оны зөвлөлгөөний чухал дүгнэлтийн үнэнийг амьдралд дахин нотолсон юм. Үндэсний эрх чөлөөний тэмцэл, социализмын хүчний үйл ажиллагааны нэгдлийн агуу их хүчин чадлыг илтгэн харуулсан энэ ялалтын тухай МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга. БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбал МАХН-ын XVII их хурал дээр дүгнэж хэлэхдээ «Энэтхэг-Хятадын хойгийн ард түмний ялалтын түүхэн ач холбогдол нь дайны хамгийн аюултай голомтыг дарж Азид энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, олон улсын түгшүүртэй байдал намжих үйл явцыг улам лавшруулах замд учирч байсан ноцтой саад тотгорыг арилгасанд оршино. Энэ бол улс түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний асар их ололт, социализмын гадаад бодлогын нэг чухал ялалт мөн»² гэж тэмдэглэсэн билээ.

Дэлхийн социализм, дэвшилт бүх хүчний идэвхтэй дэмжлэгийг хүлээсэн Энэтхэг-Хятадын хойгийн ард түмний баатарлаг тэмцлийн түүхэн ялалт нь юуны өмнө АНУ-ын Зэвсэгт хүчинд хүчтэй цохилт өгч, тус хойгийг империалист цэргийн бааз, шинэ маягийн колони болгох гэсэн империалист хүчний түрэмгий санаархлыг таслан зогсоов.

Энэ ялалтын үрээр социализмын тугийн дор Вьетнамын тавин сая ард түмэн нэгдэн нягтарч, 1976 оны арванхоёрдугаар сард хуралдсан ВКН-ын IV их хурлаас дэвшүүлсэн социалист байгуулалтын түүхэн программыг амжилттай хэрэгжүүлж эхэллээ. Үүний зэрэгцээ залуу БНАЛАУ шинээр төрж социалист лагерийн хүчин чадлыг зузаатгахад зохих хувь нэмэр оруулах боллоо. Энэтхэг-хятадын хойг дахь БНСВУ, БНАЛАУ нь ЗХУ, социалист нөхөрлөлийн бусад орнуудтай марксизм, ленинизм, пролетарийн интернационализмд тулгуурласан найрамдал бүх талын хамтын ажиллагааг улам бэхжүүлж байгаа нь тэдгээр улс орнуудын хөгжил дэвшил, социалист өөрчлөн байгуулалтад хвчтэй түлхэц болж байна. Ялангуяа БНСВУ 1978 оны зургаадугаар сард Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн гишүүн болсон явдал Вьетнам улс болон энэ байгууллагын гишүүн бусад орны хоорондын эдийн засгийн хамтын ажил

1 Коммунист ажилчны намуудын олон улсын зөвлөлгөөний баримт бичгүүд УБ., 1975. 106-р тал

2 МАХН-ын VII их хурал. Эмхтгэл, УБ., 1976, 27-р тал

лагаа, харилцан туслах явдлыг цаашид хэрэгжүүлэхэд чухал алхам болж, БНСВУ-д социализм амжилттай байгуулах таатай нөхцөлийг бүрдүүлж байгаа юм. ВКН, БНСВУ-ын Засгийн газрын тууштай интернационалч, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого, социалист байгуулалтын амжилт нь БНСВУ-ын олон улсын нэр хүндийг улам өргөж байна. БНСВУ-ын олон улсын нэр хүнд улам өсөхийн хирээр Зүүн өмнөд Ази дахь түүний нөлөө улам гүнзгийрч байгаа юм. Ялангуяа төвийг сахисан энх тайван хамтын ажиллагааны үзэл санаа Зүүн өмнөд Азид хэрэгжихэд тус районы социалист орон БНСВУ-ын нөлөө үлэмж ач холбогдолтой бөгөөд түүнд Вьетнамын засгийн газар идэвхтэй хувь нэмэр оруулж байгааг цохон тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал, БНСВУ-ын төлөөлөгчид 1976, 1978 онд Зүүн өмнөд Азийн орнуудаар хэд хэдэн удаа ажил хэрэгч найрсаг айлчлал хийсэн нь найрамдал, хамтын ажиллагааг тэдгээр оронтой тогтоож бэхжүүлэхэд чухал алхам болсон төдийгүй, нийт Зүүн өмнөд Азийн энх тайван, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд үлэмж нөлөө үзүүлсэн юм. Тэрчлэн БНСВУ шинэ тулгар хөгжиж байгаа олонхи орныг хамарсан, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнд идэвхтэй оролцож, уг хөдөлгөөнийг дэлхийн социализмтай холбоход чухал хандив оруулж байгаа юм.

Энэтхэг-Хятадын хойгийн ард түмний түүхэн ялалтын үрээр тус хойгт империалист хүчний санаархал бутцохигдож социализмын байр суурь бэхжин, нэгдсэн социалист Вьетнам улсын нэр хүнд нөлөө өссөн зэрэг нь үндэсний тусгаар тогтнол, ардчилал, нийгмийн дэвшлийн төлөө нийт Зүүн Өмнөд Азийн ард түмний тэмцлийг үлэмж зоригжуулан тус районд энх тайван, хамтын ажиллагааны нааштай хандлага зонхилох бодит бололцоог бий болгов.

Тийм учраас Зүүн Өмнөд Азид юуны өмнө америкийн цэргийн баазыг устгах, империалист орнуудын оролцоо бүхий цэрэг улс төрийн эвсэл холбоог тараах хөдөлгөөн өрнөж, тус районыг энх тайван, хамтын хамтын ажиллагааны бүс болгох гэсэн эрмэлзлэл хурцаар илрэв. Тухайлбал, америкийн цэргийн баазыг байгуулж Энэтхэг-Хятадын дайнд ашиглуулж байсан Тайланд, Филиппин зэрэг оронд 1975 оноос эхлэн америкийн цэргийн баазыг устгах хөдөлгөөн удаа дараа өрнөсөн бөгөөд 1976 оны гуравдугаар сард Тайланд өөрийн нутаг дээрх гадаадын цэргийн баазыг татан буулгахыг шаардаж, Филиппиний засгийн газар өөрийн нутаг дээрх америкийн цэргийн баазад хяналт тавихаа мэдэгдсэн юм.

Тэрчилэн 1975 оны 9-р сард Зүүн өмнөд Азийн цэрэг-улс төрийн эвсэл. СЕАТО үйл ажиллагаагаа хаасан явдал Зүүн өмнөд Азид төвийг сахисан энх тайван, хамтын ажиллагааны төлөө тэмцэл идэвхжсэнтэй холбоотой юм. Үүний зэрэгцээ Зүүн өмнөд Азийн улсуудын холбоог (АСЕАН) цаашид цэрэг-стратегийн чиглэлээр дагнан ашиглах гэсэн за рим хандлагыг Зүүн өмнөд Азийн орнууд хүчтэй эсэргүүцэж эхэлсэн юм.³ Тайландад төрийн эргэлт гарсны дараа Тайландын ерөнхий сайд АСЕАН-ы гишүүн орнуудад хандаж Зүүн өмнөд Азийн улсуудын холбоог цэрэг-стратегийн шинж чанартай болгох уриалга гаргасан бөгөөд энэ санаагаа хэрэгжүүлэхийн тулд зүүн өмнөд Азийн хэд хэдэн орноор аялсан билээ. Гэвч Тайландын уриалгыг АСЕАН-ы гишүүн орнуудын ихэнх нь дэмжээгүй юм. Филиппиний «Юнайтед Дейли Ньюс» сонинд

3 Зүүн Өмнөд Азийн улсуудын Холбоо (АСЕАН) 1967 онд байгуулагдсан бөгөөд Тайланд, Филиппин, Индонез, Малайз, Сингапур зэрэг улсууд оролцсон юм. Энэ холбоо нь гишүүн орнуудын эдийн засаг соёлын хөгжлийг түргэтгэх, Зүүн Өмнөд Азид энх тайвныг хамгаалахын оронд Энэтхэг-Хятадын дайнд ашиглагдаж байв.

«АСЕАН-ы ихэнх орон энэ үзэл санааны эсрэг байна» гэж тэмдэглэсэн бөгөөд Тайландын ерөнхий сайдыг айлчлах үеэр «Индонезийн Таймс» сонин «Цэрэг дайны эвсэл холбоо нь Зүүн өмнөд Азийн энх тайван, аюулгүй байдалд хэзээ ч тусалж байгаагүй бөгөөд гагцхүү түгшүүр төрүүлэхээс цаашгүй байсныг түүх гэрчилж байна»⁴ гэж бичиж байв. Малайз, Сингапурын сонин мөн ийнхүү эсэргүүцсэн билээ.

Зүүн өмнөд Азид гарсан ийм намжмал байдлын нааштай алхам нь тус районы улс орнуудын энх тайван, хамтын ажиллагааны үзэл санаа хэрэгжихэд зүй ёсны тус дөхөм үзүүлж байна.

1975 оноос хойш Зүүн Өмнөд Азийн орнуудын хооронд дээд хэмжээний хэд хэдэн уулзалт болж юуны өмнө өөр хоорондоо болон социалист системийн орнуудтай эдийн засгийн харилцааг идэвхжүүлэх зорилтыг дэвшүүлсэн нь эдгээр орны улс төрийн бүрэн эрх, эдийн засгийн тусгаар тогтнолыг бэхжүүлэх, улмаар тус районд бат бэх энх тайвныг бий болгох гэсэн тэдний эрмэлзлэлээс урган гарчээ. Тэгээд ч Зүүн Өмнөд Азийн есөн орон түүхэнд анх удаа бие биетэйгээ хэвийн харилцаа тогтоож, эдийн засгийн хамтын ажиллагаагаа идэвхтэй хөгжүүлж эхэлснээс гадна социалист нөхөрлөлийн орнуудтай тал бүрийн харилцааг бэхжүүлэх боллоо.

Гэтэл дэлхийг жанжлах гэсэн их гүрний гадаад бодлогынхоо дагуу дэлхийн социализм, энх тайван, намжмал байдлын эсрэг улайран тэмцэж байгаа хятадын эрх баригчид, Энэтхэг-Хятадын хойгт бодит социализмын байр суурь бэхжиж, нийт Зүүн өмнөд Азид энх тайван, хамтын ажиллагааны нааштай хандлага гарч байгаа явдалд нэн хилэгнэн эсэргүүцэж байгаа юм. Үүний улмаас хятадын эрх баригчдаас Зүүн Өмнөд Азид явуулж байгаа бүхий л үйл ажиллагаа нь тус район дахь социализмын бэхжилт, энх тайван, намжмал байдлын нааштай хандлагын эсрэг чиглэгдэж ирлээ.

Тэд юуны өмнө Зүүн Өмнөд Азийн социалист орон БНСВУ-ын хөгжил дэвшилд аль болохоор саад хийх, түүний олон улсын нэр хүнд, нөлөөгийг нь Зүүн өмнөд Азид болон дэлхий дахинд бууруулах зорилгоор БНСВУ-ын эсрэг үйл ажиллагааг идэвхжүүлж байна. Сүүлийн үед Бээжингийн эрх баригчид «хятад цагаачдын асуудал» гэгчээр шалтаглан БНСВУ-ын эдийн засагт даралт цахалт үзүүлэн улс төрийн талаар занан сүрдүүлж, улмаар БНСВУ-ын тусгаар тогтнол, энх амгалан байдалд улам бүр заналхийлж эхэллээ.

Хятадын засгийн газар БНСВУ-тай 1976—1980 оны эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурахаас шууд татгалзсан бөгөөд БНСВУ-д үзүүлэх ёстой тусламжийн зүйлээ дур мэдэн хүчингүй болгож, бүх мэргэжилтнээ татан аваад байна.

Бээжингийнхэн БНСВУ-ын эсрэг Кампучийг турхирч Вьетнам улсыг бүслэн ганцаардуулахыг зорьж байсан нь хэн бүхэнд тодорхой билээ.

Тэрхүү санаархалаа хэрэгжүүлж чадахгүй болохын хамт Кампучийн ард түмний ялалтыг мушгин гуйвуулж БНСВУ-ын нэр хүндийг ази, даян Дэлхийд гутаахыг оролдон, Вьетнамын цэрэг кампучийг эзлэн түрэмгийлсэн мэтээр цуурхал тарааж, япон болон АСЕАН-ы орнуудыг вьетнамын эсрэг тэмцэхийг шууд ятгаж эхлэлээ.

Үүний зэрэгцээ Бээжингийн зүгээс газар нутгийн маргаан үүсгэж улам бүр хүч түрэмгийлэн сүрдүүлэх боллоо. 1974 онд хятадын зэвсэгт хүчин Вьетнамын эх газраас хориодхон милл-д оршдог Парасель арлыг хүч түрэмгийлэн эзэлж тэнд байсан вьетнам цэргийг хөөн гаргасныг хэн бүхэн мэднэ. 1976 оны 2-р сарын 27-нд БНСВУ-ын хэвлэл «Нянзан» со-

4 «Проблемы дальнего Востока», 1977, № 2, с. 85.

нинд «Парасель болон Спратли арлууд бол Вьетнамын газар нутаг мөн»⁵ гэж албан ёсоор мэдэгдсэн билээ.

Хятадын тал үүнийг үл хэрэгсэн дээрх хоёр бүлэг арлыг оруулаад Өмнөд Хятадын тэнгис дэх нийт 200 гаруй жижиг бүлэг арлыг өөрийн нутаг хэмээн удаа дараа мэдэгдэж үүнийгээ археологийн судалгаагаар нотлохыг оролдож байна. Түүнчлэн Вьетнамын үндсэн нутгийн гүн руу хүртэл өнгөлзлөг хийж байна. Тухайлбал, вьетнамын Лансон, Каобанг зэрэг ховор, үнэт ашигт малтмал бүхий газар нутгаас таслан авахыг санаархаж байна. Тэд уг нутгийн гол мөрөн, гацаа тосгонд хятад нэр өгч хятадын нутаг дэвсгэр мэтээр нотлохыг оролдож байна. Хятадын зэвсэгт хүчин БНСВУ-ын агаарын болон усан хилийг удаа дараа зөрчиж Вьетнамын бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд ноцтойгоор занал хийлсээр байна.

Сүүлийн үед Бээжингийнхэн Вьетнамын хилээс холгүй оршдог Хайнань аралд үлэмж цэргийг төвлөрүүлж, хятад-Вьетнамын хил дээрх цэргийн тоог тасралтгүй нэмэгдүүлж хилийн орчимд байнга үймээн самуун дэгдээх боллоо.

Хятадын эрх баригчдын энэ бүх үйл ажиллагаа нь дэлхийн социализмын эвлэршгүй дайсан гэдгээ улам бүр илчлэн харуулж байгаа бөгөөд Хятадын эрх баригчдын жанжлан ноёрхох чиг шугам нь хөрш зэргэлдээ социалист орнуудад улам бүр бодит аюул занал учруулж байгааг нотолж байна.

ЗХУ-ын энх тайванч гадаад бодлого болон Энэтхэг-Хятадын хойгийн ард түмний ялалтын үрээр Зүүн өмнөд Азид буй болсон энх тайван намжмал байдлын нааштай хандлагад 70-аад оны дундуур хятадын эрх баригчид заналхийлэхдээ юуны өмнө тус районд АНУ-ын цэргийг байлгахыг улайран мэрийж байв.

1972 оны 2-р сард Хятад, АНУ-ын удирдагчдын хооронд болсон хэлэлцээрийн талаар америкийн «Эй би си» мэдээлэх агентлаг бичихдээ «Урьд хятадууд америкчуудыг Азиас тонил гэдэг байсан бол одоо Азид» тодорхой үүрэг гүйцэтгэхийг хүсэх болжээ»⁶ гэсэн байна. «Вашингтон пост» сонин 1975 оны 7-р сард тэмдэглэхдээ «Америкийн цэргийн баазуудыг яаравчлан татахыг хүсэхгүй байна... Хятадын хувьд гэвэл энэ районд америкийн цэрэг (зөвлөлтийн эсрэг) сөрөг хүчний чанартай байхыг дэмжиж байна»⁷ гэжээ. Хятадын эрх баригчид дараа нь Зүүн Өмнөд Азид америкийн цэргийн бааз байлгаж байгаа хоёр орон Тайланд Филиппиний эрх баригчдыг хүлээн аваад «АНУ-ыг Азиас гаргахыг хүсэхгүй байгаагаа»⁸ өгүүлснээс гадна 1977 оны 10-р сард «Америкийн цэргийн баазыг байлгахад саад хийхгүй байхыг Филиппиний засгийн газарт Бээжингийнхэн нууцаар хүссэн»⁹ тухай Швейцарийн «Базлер Цайтунг» сонин бичсэн байна. Яагаад хятадын удирдагчид, Азийн энэ бүсэнд АНУ-ын цэргийг байлгахыг сонирхож байгаа тухай АНУ-ын Батлан хамгаалах яамны сайд асан Шлессинджер мэдэгдэхдээ «Хятад одоо АНУ-ыг гол занал учруулагч гэж үзэхээ больж харин ч зөвлөлтийн эсрэг стратегид ашигтай хэмээн үзэж байна»¹⁰ гэж хэлсэн юм. Чухамхүү үүгээрээ Азийн орнуудаас олз ашиг хүүдийлэгч америкийн монополистуудын байр суу-

5 Нянзан, 27. п. 1976.

6 Бюллетень информации. 1972. № 10

7 Проблемы дальнего Востока. 1975 № 4. с. 49.

8 Проблемы дальнего Востока. 1976. № 1. с. 70.

9 Азия и Африка сегодня, 1978, № 3, с. 16.

10 Проблемы дальнего востока. 1976, № 1, с. 70.

рийг энэ районд бэхжүүлэн, хөгжиж байгаа орнуудын бие даасан байдал бэхжих үйл явцыг саатуулахад чиглэсэн АНУ-ын стратегид Бээжин таатай боломж олгосон юм.

Сүүлийн үед хятадын эрх баригчид Зүүн Өмнөд Азийн улс орнуудыг «жанжлалын эсрэг» (зөвлөлтийн эсрэг) нэгдсэн фронт гэгчид татан оруулахыг юу юунаас илүү мэрийх боллоо. Энэ ч тодорхой учир шалтгаантай юм. Тухайн орнуудын хүрээнд төдийгүй ЗХУ, социалист нөхөрлөлийн бусад орнуудтай харилцан ашигтай эрх тэгш найрамдал, хамтын ажиллагааг бэхжүүлэх эрмэлзлэл бүхий энх тайван, хамтын ажиллагааны үзэл санаа Зүүн Өмнөд Азид улам бэхжиж бодит хандлага болж байгаа явдалд хятадын эрх баригчид улам сэтгэл түгшиж байна. Тийм ч учраас ЗХУ, социалист нөхөрлөлийн бусад орнуудтай Зүүн өмнөд Азийн орнуудын тогтоосон харилцааг таслах, улмаар тэдгээр орныг Зөвлөлтийн эсрэг, дэлхийн социализмын эсрэг зэвсэг болгон ашиглах нь Хятадын эрх баригчдын хойшлуулшгүй зорилт болж байна. Үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд Бээжингийнхэн АСЕАН-ы гишүүн орнуудад хандан зөвлөлтийн эсрэг нэгдсэн фронт байгуулахыг нэг бус удаа уриалсан боловч амжилт олсонгүй.

Тэд одоо нэг талаас Зүүн Өмнөд Азийн улсуудын төрийн тэргүүн нарт хандаж найрсаг байдал гаргах, нөгөө талаас тухайн улс оронд байгаа хорлон сүйтгэгч бүлэглэлүүд болон цагаач хятад иргэдийг ашиглан төрийн бодлогод нь даралт шахалт үзүүлэх аргыг хэрэглэж байна. Тийм ч учраас Бээжингийн элч төлөөлөгчид Зүүн өмнөд Азийн улс орнуудаар удаа дараа явж «Найрамдлын» тухай ярьж байгаа боловч тухайн улс орнуудад байгаа самуун дэгдээгчдийг урьдын адил улс төр, санаа сэтгэлийн талаар дэмжин засаг төрийнх нь эсрэг турхирсаар байна. Тэр зорилгоор бээжингийнхэн тэдний заримд эд материалын, тэр ч байтугай цэрэг зэвсгийн тусламж ч үзүүлж байна. Тухайлбал, Бирмийн мэдээлэх агентлаг Хятадтай хил залгаа оршдог Бирмийн зүүн хойт районд хятадын талыг баригч бүлгийнхний зэвсэгт үйл ажиллагаа мэдэгдэхүйц идэвхжсэн тухай мэдээлжээ. Мөн Филиппин дэх маоист бүлгийнхний үйл ажиллагаа идэвжиж байгаа бөгөөд Манилийн хэвлэл үүнийг Бээжингийн тусламжтай шууд холбоотой гэж үзэж байна. Филиппиний хэвлэлийн нотолж байгаагаар хятадын эрх баригчдаас тэдгээр хорлон сүйтгэгч бүлгийнхэнд, цэргийн зэвсэг, холбооны хэрэгсэл, суртал нэвтрүүлгийн чанартай ном хэвлэлийг нийлүүлж байгаа төдийгүй, түүний командлалын бүрэлдэхүүнийг байгуулж өгсөн байна. Лаос-Хятадын хилд орогнож БНАЛАУ-ын аюулгүй байдалд заналхийлж буй оргодол дээрэмчдийг Бээжингээс зүйл бүрээр дэмжин хөхүүлж байна.

Үүнээс гадна Зүүн Өмнөд Азийн орнуудыг түгшүүлж байгаа нэг зүйл бол хилийн чанадад суугаа олон сая хятад хүмүүсийг Бээжингийнхэн өөрийн их гүрний дээрэнгүй бодлогодоо шууд ашиглахыг улам махран оролдох болсон явдал юм. Дэлхийн янз бүрийн орнуудад 25 сая гаруй хятад цагаач байгаагийн 90 гаруй хувь нь Зүүн өмнөд Азид сууж байгаа бөгөөд тус районд байгаа цагаач иргэдийн тоо сүүлийн үед үлэмж нэмэгдсээр байгаа нь хятадын хүн амаас цагаач маягаар илгээн суурьшуулах явдлыг улам нэмэгдүүлж байгаатай холбоотой. (Сүүлийн жилүүдэд зөвхөн Индонезид 40 мянга орчим хятад иргэд Бээжинд бэлтгэсэн хуурамч баримт бичиг ашиглан очсон байна).

Зүүн өмнөд Азид байгаа энэхүү олон сая хятад иргэдийг Бээжингийн эрх баригчид их гүрний гадаад дотоод бодлогодоо олон жил ашигдаж ирсэн юм. Юуны өмнө Зүүн өмнөд Азийн орнуудын эдийн засгийг тонон дээрэмдэхэд ашиглаж ирсэн бөгөөд ойрын үед хятад орныг дэл-

хийн хүчирхэг том гүрэн болгох, хятадын эдийн засгийг цэрэг дайны зорилгод бүхэлд нь чиглүүлж байгаа өнөөгийн нөхцөлд цагаач иргэдээс оруулах хувь нэмрийг улам идэвхжүүлэхийн тулд хятадын эрх баригчид үлэмж анхаарч байна. «Тус орны аж үйлдвэр, арми, техникийг шинэчлэх ажилд хилийн чанад суугаа хятад иргэдийг дайчлан оролцуулах явдал онцгой ач холбогдолтой» хэмээн БНХАУ-ын Төрийн зөвлөлийн дэргэдэх гадаадад суугаа хятадын иргэдийн хэрэг эрхлэх газрын дарга Ляо Чэн Жи энэ оны нэгдүгээр сард хэлсэн нь үүнтэй холбоотой. БНХАУ оршин тогтнож ирсэн бүр эхний жилүүдэд цагаач иргэдийн хөрөнгө оруулалтын тусгай кампани байгуулсан бөгөөд түүний анхны хуримтлал хөрөнгө 300 сая доллараас давж байв. Гонконгоос мэдээлснийг үзвэл цагаач иргэдээс Хятадын эдийн засагт сүүлийн үед жил бүр дундачаар 100-110 сая доллар оруулж байна.

1977 оны 8-р сард Хятадын Гадаад явдлын яамны сайд, Хуан Хуа «цагаач иргэдтэй харьцах явдал бол манай гадаад бодлогын чухал хэсэг мөн» гэж мэдэгдсэн бөгөөд энэ оны 1-р сард Бээжинд болсон хятадын удирдлагын зөвлөлгөөнөөр хилийн чанад байгаа хятад иргэдийн асуудал хэлэлцэж өнөөгийн Бээжингийн эрх баригчдын улс төрийн чиг бодлогыг хэрхэн яаж эрчимтэй дэмжүүлэх арга замыг заасан юм. Тэд Зүүн өмнөд Ази дахь олон сая цагаач иргэдэд хандаж, дэлхийн социализм, энх тайвны эсрэг хятадын улс төрийн бодлогыг дэмжсэн олон улсын өргөн фронт байгуулахад гар бие оролцохыг шууд уриалж байна.

Зүүн Өмнөд Азийн социалист орон-БНСВУ-ын хөгжил дэвшил, тусгаар тогтнолд заналхийлж Зүүн өмнөд Азийн энх тайван, намжмал байдалд элдэв аргаар дайсагнаж байгаа хятадын эрх баригчдын үйл ажиллагаа нь тус районыг эрхшээл нөлөөндөө оруулж их гүрний жанжлах бодлогодоо ашиглах гэсэн эцсийн зорилгыг агуулж байгаа бөгөөд энэ нь Дэлхийг жанжлах гэсэн тэдний стратегийн бүрэлдэхүүн хэсэг даруй мөн.

Хятадын бодлого улам түрэмгий шинж чанартай болж, дэлхийн энх тайван, аюулгүй байдалд ноцтой заналхийлж байгаа өнөөгийн нөхцөлд Азийн энх тайван, аюулгүй байдлын төлөө тус тивийн энхийг эрхэмлэгч улс түмний хамтарсан хүчин чармайлт улам чухал үүрэгтэй болж байна.

С. Дашцэвэл

ПОБЕДА НАРОДОВ ИНДОКИТАЯ И ПОЛИТИКА ПЕКИНА

Резюме

Многолетняя героическая борьба народов Индокитая завершилась ис торической победой над американским империализмом и созданием единой Социалистической Республики Вьетнама. В результате этой победы в Индокитае значительно укрепилась позиция социализма и прогрессивных сил Мира, открылись широкие возможности для укрепления мира, безопасности, стабильности и добрососедства между странами Юго-Восточной Азии.

Однако, великая победа народов Индокитая и особенно создание единой Социалистической Республики Вьетнама оказались не по душе Пе-

кину. В завоевании и укреплении независимости народов Индокитая Пекин видит серьезные препятствия осуществлению своих великодержавно-шовинистических, экспансионистских планов в Юго-Восточной Азии.

Наиболее показательным свидетельством реакционной сущности политики китайского, руководства является открытая борьба против социалистического Вьетнама. Как известно, Пекин за ширмой, выдуманной им «проблемы хуацяо», оказывает не только активное экономическое давление на СРВ, но и серьезно угрожает территориальной целостности и независимости СРВ, что является ярким доказательством гегемонистских за мыслов пекинского руководства в отношении соседних стран.

Чтобы усилить борьбу против ослабления международной напряженности и репятствовать дальнейшему распространению этой тенденции международных отношений на другие районы мира, пекинское руководство, начиная середины 70-х годов, начало открыто выступать за присутствие американских войск в Юго-Восточной Азии. Однако, опасаясь окончательного закрепления позиции США в этом регионе, китайские лидеры в последнее время сами решили осуществлять свои гегемонистские планы в союзе с американским империализмом в отношении стран Юго-Восточной Азии, всячески стремясь создать «единый фронт», направленный против мира и социализма.

Ради осуществления своих замыслов, маоисты с одной стороны лицемерно заявляют о «дружественных чувствах» к странам Юго-Восточной Азии, а с другой-все более усиливают политическое и экономическое давление на эти страны вплоть до вооруженных провокации против независимой Социалистической Республики Вьетнама.

По мнению автора, истинная цель китайского руководства заключается в установлении своего контроля над всеми странами Юго-Восточной Азии.

Прогрессивные силы Азии ясно отдают отчет в том, что китайская политика изо дня в день создает большую опасность для мира и бозетасности не только в данном регионе, но и во всем мире. В нынешних условиях, когда политика мира и разрядки благотворно влияют на общуто обстановку в Азии, бесспорен тот факт, что дальнейшее сполчение сов местных усилий миролюбивых сил этого региона является настоящим требованием борьбы против всякого рода агрессивных и реакционных сил и за укрепление национальной независимости и суверенитета стран данного региона.